



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/413

Мандалговь

“Дундговь-Боловсрол, соёлын түүхэн товчоон”  
номыг хэвлүүлэхэд зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, Сангийн Сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 16 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсролын салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан аймгийн боловсролын салбарын “Дундговь-Боловсрол, соёлын түүхэн товчоон” түүхийн номыг бүтээн хэвлүүлэхэд 3,000,000 (гурван сая) төгрөгийн зардлыг зарцуулсугай.

2. Ном хэвлүүлэх зардлын 3,000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



491210591